



УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023.07.04 № ХӨГ/40
танай _____-ны № _____-т

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Төрийн цахим шилжилтийн өнөөгийн байдал, цаашдын зорилтуудын талаарх Ерөнхий сайдын мэдээллийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал хийх болсныг үүгээр уламжилж байна.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000225000555



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023.07.04 № Х01/41

танай _____-ны № _____-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Төрийн цахим шилжилтийн өнөөгийн байдал, цаашдын зорилтуудын талаарх Ерөнхий сайдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ⁰⁹..... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000225000553

ТӨРИЙН ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЗОРИЛТУУДЫН ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон “Шинэ сэргэлтийн бодлого”-д цахим технологид тулгуурлан төрийн үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, хүн амыг харилцаа холбоо, өндөр хурдны интернэт сүлжээнд холбох, цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтцийг бий болгон хөгжүүлэх зорилтуудыг үе шаттай хэрэгжүүлэхээр тусгасан.

Дээрх хөгжлийн бодлого, хөтөлбөрт туссан зорилтуудыг хэрэгжүүлэх, цахим шилжилтийг үндэсний хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохион байгуулалтаар хангах, эрчимжүүлэх үүднээс харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг 2022 оны 1 дүгээр сард байгуулсан бөгөөд тус яам нь Монгол Улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд туссан зорилго, зорилтуудад нийцүүлэн “Цахим үндэстэн” болох санаачилгын хүрээнд 6 зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Дижитал дэд бүтцийн бэлэн байдлыг хангах;
- Цахим засаглалыг хөгжүүлэх;
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах;
- Тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэх;
- Инновац, үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Үндэсний хөгжлийн хурдасгуур.

Нэг. Дижитал дэд бүтцийн бэлэн байдлыг хангах талаар

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлагыг хангахуйц суурь дэд бүтцийн бэлэн байдлыг хангах Дижитал дэд бүтцийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд улсын хэмжээнд дамжуулах сүлжээний багтаамжийг нэмэгдүүлэх, үнэ тарифыг бууруулах чиглэлээр бодлого боловсруулан, сүүлийн 4 жилд шат дараалсан арга хэмжээ авч ажилласны үр дүнд төрийн өмчит аж ахуйн нэгжийн дамжуулах сүлжээний багтаамж 2017 онд 12.5 Гбит/с байсан бол 2021 онд 2,112 Гбит/с болж 168 дахин, сүлжээний хэрэглээ 3.8 Гбит/с байсан бол 2021 онд 79.5 Гбит/с болж 20 дахин нэмэгдэн, нэгж үнэ тариф дунджаар 39.5 мянган төгрөг болж 7.4 дахин буурсан байна.

Үүний үр дүнд Монгол Улсын хэмжээнд интернэтийн хэрэглээ нэмэгдэж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын харьяа Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас гаргасан үзүүлэлтээр 2021 онд нийт хүн амын 84 хувь нь интернэт хэрэглэдэг, өрхийн 80 хувь нь интернэт хандалттай, 33 хувь нь компьютертэй байсан бөгөөд 4G сүлжээ хамрагдалтаар 143 орноос 46 дугаар байрт, 3G сүлжээний хамрагдалтаар 144 орноос 14 дүгээр байрт тус тус орж байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад 11,915 хүн ажиллаж, үйл ажиллагааны орлого нь 909.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 19.8 хувь, төсөвт төвлөрүүлсэн орлого 15 хувиар нэмэгдэж 151 тэрбум төгрөгт хүрлээ.

Хот хоорондын шилэн кабелийн урт 40,760 км, хот доторх шилэн кабелийн урт 7,223 км хүрч, шилэн кабельд холбогдсон сумын тоо 227 болж, интернэт гарцын багтаамж 570 Гигабит/сек буюу өмнөх оны мөн үеэс 32 хувиар нэмэгдлээ. Мөн Монгол Улсаар дамжиж буй олон улсын интернэтийн транзит урсгалын хэмжээ 2022 оны 6 дугаар сарын байдлаар 1,410 Гигабит/сек болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.1 хувиар нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд нийт 1537 байршилд 4G сүлжээний бааз станц ажиллан, 4G сүлжээний нийт хэрэглэгчдийн тоо 2.9 сая болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.37 хувиар, хэрэглэгчдийн үүсгэсэн дата хэрэглээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.2 хувиар өслөө.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 2022 онд 1 аймгийн 1 багт 60 км урт шилэн кабель, 3,500 амьжиргааны түвшин доогуур өрхөд суурин интернэт үйлчилгээгээ хүргэх зорилгоор 154 км урт шилэн кабель тус тус суурилуулж, өндөр хурдны өргөн зурвасын суурин интернэт сүлжээг байгуулсан. Мөн алслагдсан 238 багт үүрэн холбооны 4G сүлжээ нэвтрүүлсэн ба нийт 300 мянга орчим иргэн өндөр хурдны хөдөлгөөнт интернэтэд холбогдох, мэдээ, мэдээлэл шуурхай авах, аялагч, амрагчид харилцаа холбооны бусад үйлчилгээг саадгүй, шуурхай авах боломжийг бүрдүүллээ.

Монгол Улсад хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологийг (5G) нэвтрүүлэхэд баримтлах чиглэл болон Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох аргачлалыг шинэчлэн баталж, 5G технологийн техникийн туршилтыг амжилттай хийгээд байна. Хөдөлгөөнт холбооны 5G үйлчилгээг Монгол Улсад энэ онд нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд уг технологи нэвтэрснээр өндөр хурдны интернэт, машин хоорондын холбоо, юмсын интернэт үйлчилгээ хөгжиж, харилцаа холбоо, эрүүл мэнд, дэд бүтэц, тээвэр, энтертайнмент, интернэт, жижиглэн худалдаа, үйлдвэрлэл, автоматжуулалтын салбарт томоохон шинэчлэлийг бий болгох юм.

Сансар судлалын техник технологийг хөгжүүлэх, үндэсний хиймэл дагуул хөөргөх, сансрын техник технологийн мэдээллийг боловсруулан ашиглах үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр "Монгол Улсад сансар судлалыг хөгжүүлэхэд баримтлах чиглэл (2023-2033)"-ийг баталсан. Улмаар Харилцаа холбооны хиймэл дагуул бүтээх, хөөргөх, эзэмших, ашиглах техник, эдийн засгийн урьдчилсан судалгааг хийн хиймэл дагуулын төлөвлөлтийг шинэчлэн боловсруулж, Олон улсын цахилгаан холбооны байгууллагад хүргүүлээд байна.

Хоёр. Цахим засаглалыг хөгжүүлэх талаар

Нийгэм, эдийн засгийн бүх салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологи, инновацыг нэвтрүүлж, бүтээмж, өрсөлдөх чадвар, үр ашгийг нэмэгдүүлэх замаар хүнд сурталгүй, ил тод засаглалыг бүрдүүлэх Цахим засаглал зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгасны дагуу тоон гарын үсгийг түгээх ажлыг эрчимжүүлэн, 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 383,974 иргэн, 85,730 хуулийн этгээд, 14,249 төрийн албан хаагчид тоон гарын үсгийг олгоод байна.

Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем "ХУР"-д төрийн 108 байгууллага, хувийн хэвшлийн 269 байгууллага тус бүр холбогдож, 566 төрлийн хязгаарлалттай мэдээллийг 1.1 тэрбум удаа солилцжээ. Танилт нэвтрэлтийн системд 1,689,943 хэрэглэгч бүртгэгдсэн бөгөөд төрийн 47 байгууллага, хувийн хэвшлийн 111 байгууллагын 218 систем ашиглаж байна. Төрийн үйлчилгээний "e-Mongolia" системд 71 төрийн байгууллагын 806 үйлчилгээг холбосон бөгөөд 1,484,723 хэрэглэгч бүртгүүлэн, 20,767,298 удаа цахим хэлбэрээр төрийн үйлчилгээ авч, 123 тэрбум төгрөгийн шууд бус зардал хэмнэжээ.

Үйлчилгээний байгууллагууд иргэдээс заавал цаасан хэлбэрээр авчрахыг шаарддаг байсан лавлагаа, тодорхойлолтыг иргэний өөрийнх нь зөвшөөрлийн үндсэн дээр холбогдох мэдээллийг авах боломжийг бүрдүүлсэн *lavlagaa.e-mongolia.mn* цахим систем нэвтрүүлснээр 1 сарын хугацаанд 11 байгууллагын 69 нэр төрлийн лавлагаа, тодорхойлолтыг 15,000 удаа олгоод байна.

Төрийн байгууллагын хэмжээнд албан хэрэг хөтлөлтөд ашиглагддаг 15 ялгаатай систем өөр хоорондоо албан бичиг солилцох нөхцөлийг бүрдүүлсэн "DocX" цахим системийг нэвтрүүлж, төрийн 5,483 байгууллага дотоод удирдлагын нэгдсэн системийн ялгаатай байдлаас үл хамаарч албан бичгийг цахим хэлбэрээр солилцох, улмаар цаасны зардал буурах боломж бүрдлээ.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагаас эрхлэн гаргадаг Цахим засаглалын хөгжлийн индексээр 2022 онд 18 байраар урагшилж, 74 дүгээр байрт орлоо.

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сард баталсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хууль болон Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтэд анхаарч, дээрх хуулиудыг дагалдан гарах 17 журмыг Засгийн газрын тогтоол болон Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын тушаалаар батлуулан мөрдөж байна.

Түүнчлэн Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам хамтран төрийн байгууллага хооронд болон төр, хүн, хуулийн этгээдийн цахим хэлбэрээр мэдээлэл солилцох нөхцөлийг сайжруулах, хүн, хуулийн этгээдийн төрийн байгууллагаас авах үйлчилгээний чирэгдлийг багасгах, төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотой хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийт 430 орчим хуулийг судалж үзэхэд "бичгээр" буюу "цаасан хэлбэрээр" гэсэн агуулга бүхий үг хэллэгтэй 169 хуулийн 869 хэсэг байна. Тэдгээр нь цахим хэлбэрээр үйл ажиллагаа явуулахад саад болсон, мөн "цаасаар", "өөрийн биеэр", "бичгээр хүргүүлнэ" гэсэн цаасан суурьтай баримт бичгийг шаардаж, төрийн байгууллагаас авах үйлчилгээг өөрийн биеэр очиж авах хүндрэлтэй эрх зүйн орчин үйлчилж байгааг шинэчлэн сайжруулахаар ажиллаж байна.

Төрийн уламжлалт үйлчилгээг шинэ шатанд гаргаж, төрийн үйлчилгээний чанар, стандарт, хүртээмж, нэр төрлийг нэмэх үндсэн чиг үүрэг бүхий Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Цахим хөгжил, харилцаа холбооны яамны дэргэд байгууллаа. Тус төрийн захиргааны байгууллага нь төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан төрийн үйлчилгээ хүргэх үйл ажиллагааг нэгдсэн зохион

байгуулалтаар хангах бөгөөд нийслэлийн 6 үйлчилгээний нэгдсэн төв, нийслэл дэх 59 төрийн үйлчилгээний цэг, аймаг дахь 21 үйлчилгээний нэгдсэн төв, 309 сум, суурин газар, нийт 395 цэгт төрийн 431 үйлчилгээг хүргэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.

Эдгээр цэг, төвүүд байгуулагдсанаар иргэд заавал аймгийн төв, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд очиж авах боломжтой байсан үйлчилгээг өөрт хамгийн ойр үйлчилгээний цэгээс авах боломж бүрдэнэ. Нэгдсэн зохион байгуулалт бүхий тусгайлсан үйлчилгээний байгууллага бий болсноор үйлчилгээний чанар, шийдвэрлэх хурд, хяналтын тогтолцоог бүрдүүлэн, хүнд сурталгүй, хүртээмжтэй төрийн үйлчилгээг бий болгож, орон нутагт салбаргүй төрийн байгууллагын үйлчилгээг хүргэх боломжтой болох юм.

Гурав. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар

Цахим орчинд үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэн, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, төр, хувийн хэвшил, иргэний мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэн, мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангах зорилтын хүрээнд:

Манай улс кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бэхжүүлж, онц чухал мэдээллийн дэд бүтцийг хамгаалах, кибер аюулгүй байдлыг хангах боловсон хүчнийг чадавхжуулах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, кибер халдлага, зөрчилтэй тэмцэх бүтцийг бүрдүүлэх зорилго бүхий "Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги"-ийг 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар баталсан. Тус стратеги нь 5 үндсэн зорилттой бөгөөд 2027 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засагт хохирол учруулж болохуйц мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ бүхий онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй төрийн 134 байгууллага, хувийн хэвшлийн 82 байгууллагыг тодорхойлж, Засгийн газрын тогтоолоор уг жагсаалтыг баталсан. Эдгээр байгууллагууд кибер аюулгүй байдлыг өндөр түвшинд хангаж, хариуцсан мэдээллийн системийн хэвийн тасралтгүй ажиллагааг хангаснаар төрийн тогтвортой үйл ажиллагаа, иргэдийн тайван ажиллаж амьдрах орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Хүний хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь дэлхий дахинаа тулгамдаад байгаа чухал асуудлын нэг бөгөөд Монгол Улс Хүний хувийн мэдээллийг хамгаалах хуультай болж, салбар бүрд хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангах, хүн өөрийн мэдээллийн эзэн байх эрхийг хамгаалсан зохицуулалтыг тодорхой болгосон. Хуулийн хүрээнд хүний биометрик мэдээлэл буюу дахин давтагдашгүй биеийн өгөгдөл болох гарын хурууны хээ нийт 2,464 байгууллагад 637,024 иргэний хурууны хээний мэдээлэл цугларсан байсныг шалгаж тогтоон, устгах ажлыг зохион байгуулаад байна. Мөн хүний хувийн мэдээлэлд гуравдагч этгээд хандсан тухай мэдэгдэл хүргэх системийг 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс ашиглалтад оруулж, 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар нийт 14,457,136 удаа иргэдэд мэдэгдэл хүргээд байна.

Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас 2 жил тутамд гаргадаг "Кибер аюулгүй байдлын индексийн судалгаа"-аар манай улс 2017 онд 104 дүгээр

байр, 2018 онд 85 дугаар байр, 2020 онд 120 дугаар байрт тус тус эрэмбэлэгдсэн байна.

Үндэсний дата төв УТҮГ-т байрлах төрийн байгууллагуудын цахим шуудан болон цахим хуудасны серверт чиглэсэн сэжигтэй хандалтын тоо 2019 онд 6.5 сая, 2020 онд 371 саяд хүрсэн бол 2021 онд 496.7 саяд хүрч, сэжигтэй хандалтын тоо жил ирэх тутам нэмэгдсээр байна.

Цаашид иргэд, хуулийн этгээдийн кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, мэдээллийн системийг нөхөн сэргээх үйл ажиллагааг зохицуулж, мэргэжлийн удирдлагаар хангах Нийтийн төвийг байгуулан үйл ажиллагааг жигдрүүлж, кибер халдлага, зөрчилтэй тэмцэх олон улсын болон гадаад улсын байгууллагуудтай мэдээлэл, харилцан туршлага солилцох хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлого барин ажиллаж байна.

Дөрөв. Тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэх талаар

Үндэсний статистикийн хороо, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар хамтран 2021 онд хийсэн "Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ" судалгаагаар судалгаанд оролцогчдын 43.8 хувь нь мэдээллийн ур чадвартай, 38.8 хувь нь харилцаа холбооны ур чадвартай, 27 хувь нь асуудал шийдвэрлэх ур чадвартай, 9.8 хувь нь программ хангамжийн ур чадвартай, 6.4 хувь нь аюулгүй байдлын ур чадвартай гэж гарсан байна.

Цахим ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний мэдээллийн нийгэмлэгийн агентлагийн буцалтгүй тусламжаар "Цахим ур чадвар олгох төв" байгуулах төслийг хэрэгжүүлж, 2022 оны 12 дугаар сард уг төвийг нээлээ. Энэхүү төв нь бүх нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх, тэр дундаа харааны бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх чиглэлээр сургалт, арга хэмжээ зохион байгуулахаас гадна үндэсний контент үйлдвэрлэгчдийг дэмжих зорилготой.

Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хүний нөөцийн асуудал, ялангуяа төрийн албанд тулгамдаж байгааг анхаарах шаардлагатай байгаа нь төрийн байгууллагын 87 хувьд нь программ хангамж, мэдээллийн сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн технологи, мэдээллийн систем, өгөгдлийн шинжилгээ, хиймэл оюун ухаан, автоматжуулалтын систем хариуцан ажиллах мэргэжилтэн хангалтгүй байгаагаас харагдаж байна.

Иймд Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас мэдээллийн технологийн салбарт хүлээн зөвшөөрөгдөх, олон улсын мэргэжлийн холбоо, стандартын байгууллагаас олгогддог сертификатын жагсаалтыг батлан, дээрх мэргэжлээр их, дээд сургууль төгсөж, дипломын боловсрол эзэмшээгүй ч олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификат авсан, ур чадвар эзэмшсэн мэргэжилтнүүдийг мэдээллийн технологийн салбарт ажиллаж, цахим шилжилтэд хувь нэмрээ оруулах боломжийг нээх бодлого баримталж байна.

Тав. Инновац, үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар

Мэдээллийн технологи, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, блокчэйнд суурилсан платформууд, программ хангамж, үндэсний тоон контентийг хөгжүүлж, газрын ховор

элементэд түшиглэн электроникийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, экспортод гарган эдийн засгийн шинэ секторыг хөгжүүлэх “Инноваци, үйлдвэрлэл” зорилтын хүрээнд “Олборлолтоос оюун ухаанд” санаачилгыг хэрэгжүүлж, мэдээллийн технологийн салбарын эдийн засгийн салбарт эзлэх хувийг нэмэгдүүлэх, тус салбарын хүний нөөцийг чадавхжуулах, хөрөнгө оруулалтыг татаж, уул уурхайд суурилсан эдийн засгаас оюун санаа, мэдлэг оюун шингэсэн эдийн засгийг бий болгох чиглэлд ажиллаж байна.

Үүний эхлэл болгож төрийн программ хангамж худалдан авах ажиллагааг шинэ түвшинд гаргаж, үргүй зардлыг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх үүднээс дотоодын компаниудын хөгжүүлж бий болгосон программ хангамжийн шийдлийг санал болгох *mindgolia.mn* платформыг 2022 оны 12 дугаар сард нээж, 121 компанийн 188 бүтээгдэхүүнийг байршуулав. Төрийн байгууллагууд мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалт хийхдээ бэлэн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах боломж бүрдэж, программ хангамжийн компаниуд инновац, шинэ мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ дотоод, гадаадын зах зээлд гаргах, улмаар өрсөлдөх чадвар нэмэгдэх боломж бүрдэнэ.

Түүнчлэн программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудыг татварын бодлогоор дэмжих, мэдээллийн технологийн гарааны бизнес эрхлэгч компаниудыг 2023 оны 1 дүгээр сараас эхлэн таван жилийн хугацаанд мэдээллийн технологийн үйл ажиллагаанаас олсон орлогын албан татвараас чөлөөлөхөөр боллоо.

Зургаа. Үндэсний хөгжлийн хурдасгуур

Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Барилга, хот байгуулалтын яамтай хамтран Үндэсний хаягжилтын мэдээллийн нэгдсэн системд зип код, шуудангийн нэгдсэн код, газар нэгжийн тайлбар зэрэг олон хаяг, дугаарыг нэгтгэн нэгдсэн хаягтай болох шийдлийг боловсруулсан бөгөөд энэ санг ил тод болгож, хэрэглээнд нэвтрүүлснээр шуудангийн үйлчилгээ, газар зохион байгуулалт, такси, хүргэлт зэрэг олон асуудлыг шийдвэрлэхэд дэвшил гарна.

Мөн уул уурхайн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, нээлттэй, цахим биржийг хөгжүүлж, уул уурхайн бүтээгдэхүүнийг олон шат дамжлагагүй эцсийн хэрэглэгч зах зээлийн үнээр худалдан борлуулах боломжтой болж, биржийн арилжааны талаар төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан ард иргэдэд цаг алдалгүй мэдээлэл хүргэж ил тод байдлыг хангана.

Монгол Улсын уул уурхайн гол бүтээгдэхүүний нэг болох нүүрсийг олборлох, чанарыг тогтоох, тээвэрлэх, боомтод хүргэх бүхий л үйл ажиллагааг технологийн тусламжтайгаар хянах шийдлийг боловсруулж, нэвтрүүлнэ.

Улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналт, мэдээллийн нэгдсэн систем, гадаадын иргэний виз бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, систем, Монгол Улсад суугаа гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын мэдээллийн нэгдсэн системийг тус тус шинэчлэх ажилд салбар дундын зохицуулалтыг ханган ажиллаж байна.

Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлж эхэллээ.

Анхан шатны 538, лавлагаа шатлалын 48, хувийн 60 гаруй эмнэлэг эрүүл мэндийн статистикийн программ, даатгалын системтэй холбогдон мэдээлэл солилцсоноор 49,000 хэрэглэгчийн эрүүл мэндийн цахим карт үүссэн байна.

Монгол Улсын өнцөг булан бүрд ажиллаж, амьдарч байгаа шилдэг багшийн бэлтгэсэн цахим хичээлийг суралцагч нь орон зай, цаг хугацаанаас үл хамааран насан туршдаа суралцах, цахим контентын нэгдсэн сан бүрдүүлэх зорилго бүхий *medle.mn* сургалтын нэгдсэн платформыг нэвтрүүлж, 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 5,017 багш, 3,642 контент боловсруулах санал ирүүлснээс 1,862 хичээлийг байршуулан нэг сая гаруй хэрэглэгч хандсан байна.

Цэцэрлэгийн "сугалаатай" бүртгэлийг халж, хүүхдийг анх удаа төрийн үйлчилгээний нэгдсэн системээр бүртгэж, оршин суугаа хаягийн ойролцоо хуваарилалт хийлээ. Энэ нь эцэг эх, асран хамгаалагчдыг дэмжсэн, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан, нийслэлийн түгжрэлд эерэг нөлөөлөл үзүүлсэн, хүнд суртал, авлигаас ангид, ил тод үйлчилгээ болж чадсан гэж үзэж байна.

Газрын кадастрын нэгдсэн системд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нарын хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагааг эрхлэн явуулж, газрын бүртгэлийг баталгаажуулах, цахимжуулах ажлыг хэрэгжүүлснээр улсын хэмжээнд нийт өмчлөх эрх үүссэн 577,180 газар, эзэмших эрх үүссэн 457,534 газар, ашиглах эрх үүссэн 5,963 газар буюу нийт 979,697 газар тус тус бүртгэгдэж баталгаажсан байна.

2022 оны байдлаар Газрын биржийн цахим системээр нийт 12,880 газрын дуудлага худалдаа, 624 газрын төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 76,817 газрын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг бүртгэж оруулжээ.

Хот байгуулалтын кадастрын цахим системд иргэн, хуулийн этгээд барилга барих хүсэлт гаргахаас эхлээд архитектур төлөвлөлтийн даалгавар, барилга байгууламжийн ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл болон ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гаргах зэрэг шат дараалсан үйл ажиллагааг цахим орчинд хүлээн авч, түргэн шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн.

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг танхимаар зохион байгуулж байх үед жилд дунджаар 4 тэрбум төгрөг улсын төсөвт ордог байсан бол Газрын биржийн цахим систем ашиглан дуудлага худалдааг цахимаар зохион байгуулснаар дуудлага худалдааны орлогын хэмжээ 6.1 дахин нэмэгдэж, 24.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээд байна.

Долоо. Засгийн газраас цахим шилжилтийн талаар 2023 онд баримтлах бодлого, чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Цахим хөгжлийг дэмжих хуулиудын хэрэгжилтийг хангаж, цахим үндэстэн болох үйл хэргийг эрчимжүүлэх, мэдээллийн технологийн хөгжил дэвшлийг салбар бүрд, иргэн бүрд хүргэх зорилгоор заавал биеэр эсхүл цаасаар мэдээлэл солилцохоор заасан, иргэн, хуулийн этгээд төртэй болон өөрөө хоорондоо хамтран ажиллах, үйлчилгээ авахад чирэгдэл учруулж болох хууль, тогтоомжуудын судалгааг хийж, хууль хоорондын давхардал, хийдлийг арилгах зорилгоор зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр төлөвлөж байна.

Үндэсний дата төв УТҮГ-ын үйл ажиллагааг олон улсын дата төвийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан Cloud провайдер хэлбэрт шилжүүлж, үндэсний клауд дэд бүтцийг бий болгосноор хоорондоо зохицдоггүй тоног төхөөрөмж, техник хангамж бий болдог асуудлыг цэгцэлнэ.

2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу Зөвшөөрлийн нэгдсэн сан үүсгэж, зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах үйл ажиллагааг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх, түүнчлэн хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой үйлчилгээ, санхүү, татвар болон нийгмийн даатгал зэрэг төрөөс хуулийн этгээдтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг цахим нэг цонхонд төвлөрүүлж, бизнес эрхлэхэд таатай нөхцөлийг бүрдүүлсэн *e-business.mn* платформыг бий болгоно. Тус платформ нээгдсэнээр дэлхийн хаана ч байсан компани байгуулах, тусгай зөвшөөрөл авах, сунгах, татвар, нийгмийн даатгалаа төлөх боломж бүрдэж, бизнесийн үйл ажиллагаа ил тод, тунгалаг болж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл, хамтран ажиллах сонирхлыг нэмэгдүүлнэ.

"Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр тогтоолын 2-т заасан "Монгол хүний удмын санг цус ойртолт, удамшлын өвчлөлөөс сэргийлэх зорилгоор "Угийн бичиг"-ийг айл өрх бүрд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөтлүүлэн хэвшүүлэх ажлыг орон даяар 2024 онд багтаан хэрэгжүүлэх, шаардлагатай бол холбогдох судалгаанд тулгуурлан ургийн овгийн нэршлийг шинэчлэх арга хэмжээг зохион байгуулах", иргэдэд удам угсаагаа мэдэж, хөтлөх үндсэн сурвалж болох архивын мэдээлэлтэй нийтийн мэдээллийн дэд бүтцээр холбогдсон угийн бичиг хөтлөх системийг дэмжин ажиллана.

Мөн Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциациатай хамтран хэрэгжүүлэх "Ухаалаг засаг-2 төсөл"-ийн хүрээнд төрийн цахим үйлчилгээний суурь дэд бүтэц болох үндсэн болон дэмжих системийг өргөтгөн хөгжүүлж, бүх шатны төрийн байгууллагыг холбох дундын үүлэн шийдлийг нэвтрүүлж, тоон гарын үсгийн дэд бүтцийг иж бүрнээр нь шинэчлэн, Үндэсний дата төвийн хүчин чадлыг нэмэгдүүлж, кибер аюулгүй байдлыг хангах, дижитал эдийн засгийн өсөлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

"Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын дагуу Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасан мэдээлэл хариуцагч 68 төрлийн мэдээллийг ил тод, нээлттэй байлгахаар зохицуулсан. Тус журмын хэрэгжилтийн хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагуудаас 34 байгууллагыг сонгон өөрийн цахим хуудсандаа нээлттэй байлгахаар заасан мэдээллийг цаг тухайд нь байршуулж байгаа эсэхэд үнэлгээ хийхэд энэ оны байдлаар 41.16 хувь гэж гарсан байгааг дээшлүүлж, иргэдийн мэдээлэл авах үндсэн хуулиар олгогдсон эрхийг хангаж ажиллана.

Сансар судлалын салбарыг хөгжүүлэх хүрээнд эмэгтэй сансрын нисгэгч бэлтгэх, сансар судлалын чиглэлээр ОХУ-ын "Роскосмос" улсын үйлдвэрийн газартай хамтран ажиллана.

Түүнчлэн БНХАУ-ын Бээжин хотод төвтэй Ази, Номхон далайн Сансрын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Газар зүйн тэнхимд БНХАУ-ын цаг уурын

"FY-2" хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах газрын станцын лаборатори байгуулна. Хиймэл дагуулын газрын станц ашиглалтад орсноор Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан байгаль цаг уурын мэдээллийг цаг тутамд авч, ашиглах боломж бүрдэх юм.

---oOo---